



ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

Түүхэнд энэ өдөр

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Г.САЙХАНБАЯР НҮБ-ЫН ЭНХИЙГ САХИУЛАХ АЖИЛЛАГААНД ЦЭРЭГ ХАНДИВЛАГЧ ОРНУУДЫН САЙДУУДАЙ ЦАХИМААР ХУРАЛДАВ

2021 SEOUL UN PEACEKEEPING MINISTERIAL
7-8 December, Seoul, Republic of Korea

ACTION FOR PEACEKEEPING



НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд цэрэг хандивлагч орнуудын Батлан хамгаалахын сайд нарын цахим хурал өчигдөр зохион байгуулагдсан. Тус хуралд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр оролцлоо. Энэхүү хуралдааныг Бүгд Найрамдах Солонгос улс, НҮБ-тай хамтран зохион байгуулсан бөгөөд дэлхий даяар тархаад буй цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан цахимаар зохион байгуулсан юм.

НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд цэрэг хандивлагч орнуудын Батлан хамгаалахын сайд нарын хуралдаан нь 2014 оноос эхлэн зохион байгуулагдаж ирсэн

бөгөөд дэлхийн улс орнуудын төр, засгийн тэргүүн, Батлан хамгаалахын болон Гадаад харилцааны сайд, олон улсын байгууллагын тэргүүнүүд, эрдэмтэн судлаачид оролцдог юм. Түүнчлэн энэхүү хуралдаан нь НҮБ-ын гишүүн орнууд НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны цаашдын зорилгын талаар хэлэлцэх индэр болдог ороо онцлогтой.

Энэ удаагийн хуралдааныг Ази тивд анх удаа зохион байгуулсан бөгөөд дэлхийн 100 гаруй орны төлөөлөгчид оролцож энхийг сахиулах ажиллагааны өнөөгийн байдал, тулгамдаж буй сорилтуудын талаар хэлэлцэж, цаашдын бодлогоо хамтдаа тодорхойллоо.

1937 он.

ЦЯЯ-ны сайд бөгөөд Бүх цэргийн жанжны 373 тоот тушаалаар дарга нарт үндэсний хэл бичиг, үгийн дүрэм, тоо бодлого, геометрийн бодлого, алгебр, дэлхийн байдал, байгалийн шинжилгээ, физик, хими гэсэн хичээлүүдийг 1938 оноос эхлэн заан сургахаар болжээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-6	-22

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	24

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,852.0	2,855.0
EUR	3,228.0	3,235.0
CNY	447.0	448.0
RUB	39.20	39.60
JPY	25.05	25.15
KRW	2.40	2.41

ЗУРХАЙ

2021.12.08 ЛХАГВА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 05/

ӨВЛИЙН ДУНД ЦАГААН ХУЛГАНА САРЫН НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ ЦАГААН БАР ӨДӨР

ҮС ЗАСУУЛБАЛ:

Эд, мал АРВИЖНА.

НАРАН УРГАХ, ШИНГЭХ: 08.29-17.00

Барилдлага:

Идэр

Шүтэн барилдлага:

Тийн мэдэхүй

Суудал:

Мод

Энэ өдөр нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, сан тавиулах, угаал үйлдэх, амилуулах, өглөгийн түллэг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, гэр, байшингийн суурь тавихад сайн. Золиг гаргах, сэтгэлд сэтгэй газар очиход муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогосод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, мал арвидна.

АНУ-ЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ



Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай ноён Адам Фаррарыг хүлээн авч уулзлаа. Уулзалтаар талууд хоёр улсын Батлан хамгаалахын хамтын ажиллагааны өнөөгийн байдлыг дүгнэж, хамтын ажиллагаа тогтсон уламжлалаар цаашид үргэлжлэн амжилттай өргөжин хөгжинө гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлээд Ирак, Афганистанд хамтран үүрэг

гүйцэтгэсэнд талархлаа илэрхийлэв. Уулзалтад Гадаад хамтын ажиллагааны газрын дарга хурандаа Б.Бат-Эрдэнэ, тус газрын мэргэжилтэн хошууч Ц.Даваадорж, АНУ-ын Төрийн департаментын Монголын асуудал эрхэлсэн ноён Дарин Фостер, АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Батлан хамгаалахын атташе дэд хурандаа Филипп Лью нар байлцав.

ЗХЖШ-ЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗАР 2021 ОНЫ АЖЛАА ТАЙЛАГНАВ

Зэвсэгт хүчний Жанжин штабын Ажиллагааны удирдлагын газрын 2021 оны үйл ажиллагааны тайлангийн хурал өчигдөр БХЯ, ЗХЖШ-ын 320 тоот танхимд зохион байгуулагдлаа. Тайлангийн хуралд Зэвсэгт хүчний Жанжин штабын орлогч дарга, бригадын генерал Ч.Цогтжаргал, Хяналт-шинжилгээ үнэлгээний газрын даргын орлогч, дэд хурандаа Г.Амартүвшин, ЗХЖШ-ын АУГ-ын бие бүрэлдэхүүн, Зэвсэгт хүчний 032, 142, 284 дүгээр ангийн захирагч нар оролцлоо.

Хурлын эхэнд ЗХЖШ-ын АУГ-ын болон тус газрын харьяа Зэвсэгт хүчний 032, 142, 284 дүгээр ангиудын 2021 оны онцлох болон бүтээлч ажлуудын үзэсгэлэнтэй танилцав.

ЗХЖШ-ын АУГ-ын 2021 оны үйл ажиллагааны тайланг газрын дарга бригадын генерал С.Дашзэвэг

илтгэж, хурлын төгсгөлд тайлантай холбоотой санал, шүүмжлэлийг сонсохын зэрэгцээ ирэх оны зорилго, зорилтуудаа тодорхойлон, ЗХЖШ-ын удирдлагад тавих тулгамдаж буй асуудал, санал хүсэлтээ илэрхийлэв.

Үүний дараа ЗХЖШ-ын орлогч дарга бригадын генерал Ч.Цогтжаргал Ажиллагааны удирдлагын газар, харьяа ангиудын захирагч нарт баяр хүргэж, 2021 онд Зэвсэгт хүчний үйл ажиллагаа зохион байгуулалтын өндөр түвшинд хангалттай биелэгдсэн хэмээн онцлоод 2022 онд өмнө жилийнхээ дэвшүүлсэн зорилго, зорилтоо дахин бататган бүрэн дүүрэн гүйцэтгэхийг захив.

Мөн тайлантай холбоотой зарим санал хүсэлтийг ЗХЖШ-ын даргад уламжлахаа илэрхийлсэн юм.



“ЗӨВ МАНЛАЙЛАЛ” УРАЛДААНЫ УДИРДАМЖ

Нэг. Уралдааны зорилго:

1. Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг нийгэмд сурталчлах зорилго бүхий цахим хөгжүүлэлтийг идэвхжүүлэх, хандалтыг нэмэгдүүлэх замаар түүхт ой, Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, анги, салбар, цэргийн алба, тэргүүний цэргийн алба хаагчдыг олон нийтэд сурталчлах;

Лүргэлжлэл нь II нүүрт/

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН
373,666 +139

ЭДГЭРСЭН
538,288

НАС БАРСАН
1,942 +3

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
6582 +110

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ
60

ЭДГЭРСЭН
6395

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 267,339,323

Эдгэрсэн

Нийт: 240,730,560

Нас барсан

Нийт: 5,285,713

цаг үе, үйл явдал

ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛЫНХАН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГА ДҮГНЭВ



Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын 2021 оны үйл ажиллагааны тайлангийн хурал энэ сарын 6-ны өдөр боллоо. Хуралд ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга бригадын генерал С.Дашзэвэг нарын албаны хүмүүс оролцсон юм. Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, хошууч генерал Б.Амгаланбаатар Хуурай замын цэргийн командлал нь 2021 онд бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээ, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах арга хэмжээ, хуулиар олгосон тусгайлсан чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ, хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг хэрхэн гүйцэтгэсэн талаар танилцуулж, төгсгөлд нь ЗХЖШ-ын удирдлагад тавих санал хүсэлтээ илэрхийлэв. Үүний дараа бригадын

генерал С.Дашзэвэг командлалын бүрэлдэхүүнд баяр хүргэж, 2021 оны үйл ажиллагааг хангалттай биелэгдсэн хэмээн онцлоод 2022 онд дэвшүүлсэн зорилт, зорилгоо бүрэн дүүрэн гүйцэтгэхийг захиад, тайлантай холбоотой зарим санал хүсэлтийг ЗХЖШ-ын даргад уламжлахаа илэрхийллээ.

Хурлын төгсгөлд Хуурай замын цэргийн командлал болон түүний харьяа Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудаас 2021 онд боловсруулсан удирдлага төлөвлөлтийн баримт бичиг, хамтарсан хээрийн сургууль, КШС-аар боловсруулсан бичиг баримттай танилцсан юм. Ташрамд дурдахад, ХЗЦК-ын 2021 оны үйл ажиллагааны тайлангийн хуралд Хуурай замын цэргийн харьяа Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийдын удирдлага цахимаар оролцлоо.

“ЗӨВ МАНЛАЙЛАЛ” УРАЛДААНЫ УДИРДАМЖ

Түрүүч нь I нүүрт/

2. Төр, хувийн хэвшлийн хэвлэл, мэдээллийн байгууллагын харилцаа, үр ашгтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, харилцан үйл ажиллагаандаа дэмжлэг үзүүлэх;

3. Түүхт ой тохиож буй энэ жил хугацаат цэргийн алба хааж буй цэргийн алба хаагчдыг сурталчилж, тэдэнд түүхэн ойн ач холбогдлыг судлах сэдэл, тэмүүллийг бий болгох, олон нийтэд Батлан хамгаалах салбарын түүхэн хөгжил, онцлох үйл явдлуудыг сурталчлан таниулах;

4. Шинэ үеийн төлөөлөл болсон залуусын бие хүний хөгжлийг дэмжих, хөгжүүлэх, тэдний дундаас илтгэх авьяас чадвартай, бусдадаа эергээр нөлөөлөх, зөв харилцаа хандлага, хүмүүжил төлөвшилтэй манлайлагч нарыг илрүүлэн гаргаж ирэх, тэдний авьяас, чадварыг нээж хөгжүүлэх, зөв, цэгцтэй сэтгэж, өөрийн үзэл бодлоо уран яруу илэрхийлэх арга зүйд сургах;

5. Цэргийн алба хаагчдад эх оронч үзэл, хүмүүжил, эх орноо батлан хамгаалах зоригийн чанар, итгэл үнэмшлийг төлөвшүүлэх болон хүмүүжлийн бусад үйл ажиллагаанд эдгээр зөв манлайлалтай, тэргүүний байлдагчдыг идэвхтэй татан оролцуулах замаар дайчдыг цэргийн албанд богино хугацаанд дасгах, цэргийн албыг бэхжүүлэх, албандаа хандах эерэг хандлагыг төлөвшүүлж, албаны ухамсрыг дээшлүүлэхэд нь эергээр нөлөөлөх тогтолцоог бий болгож хөгжүүлэх зэрэг үндсэн зорилготой.

Хоёр. Хамрах хүрээ:

Энэхүү уралдаанд Монгол Улсын өнцөг булан бүрд байрлаж буй Зэвсэгт хүчний бүх нэгтгэл, анги, салбарт цэргийн алба хааж байгаа цэргийн хугацаат албаны түрүүч, байлдагчид оролцоно.

Гурав. Уралдааны журам, хугацаа, үе шат:

Тус уралдаан нь 3 үе шаттай явагдана.

Нэгдүгээр шат: Оролцогчид “Эх орон” сэдвийн хүрээнд өөрийн боловсруулж бэлтгэсэн илтгэлийн хүрээнд 3 минутын багтаамжтай бичлэг хийж, уг бичлэгийг Батлан хамгаалахын “Соёмбо” редакцын “Дуулга” студийн фейсбүүк хуудасны чат буюу мессенжерээр 2021 оны 12 дугаар сарын 20-ны дотор ирүүлж, онлайннаар оролцоно. Уралдааныг шүүх шүүгчдийн комисс цахимаар хүлээн авсан бичлэгүүдийг үзэж шилдгийн шилдэг 10 илтгэгчийг шалгаруулна.

Хоёрдугаар шат: Нэгдүгээр шатнаас шалгарсан “Шилдэг 10 оролцогч”-дод зохион байгуулагчдын зүгээс хувийн дугаар олгон тухайн оролцогчийн бичлэгийг нэгтгэл, анги, салбарын Соёл хүмүүжлийн офицероор дамжуулан “Дуулга” студийн фейсбүүк хуудсанд тодорхой хугацаагаар байршуулна. Цахим хуудсанд байршуулсан бичлэгээс хамгийн олон лайк, хуваалцах буюу share цуглуулж чадсан 5 бичлэгийг шалгаруулан гуравдугаар шатанд оролцуулна. Өөрөөр хэлбэл энэ шатны шалгаруулалтыг зөвхөн үзэгчид хийх юм.

Гуравдугаар шат: Хоёрдугаар шатнаас шалгарсан “Шилдгийн шилдэг-5” оролцогчийг төгсгөлийн шатны шалгаруулалт шууд дамжуулалтаар үзэгчдэд хүрнэ. Шууд дамжуулалтын үеэр шүүгчдийн зүгээс Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага үүсэн байгуулагдсаны 110 жилийн ой, Зэвсэгт хүчний 100 жилийн түүхэн ойттой холбоотой асуултууд бэлтгэсэн байх ба оролцогч асуултыг сугалж, сугалсан асуултад хариулна. Оролцогчдын асуултад зөв, оновчтой хариулсан байдлыг харгалзан шүүгчид 0-10 оноогоор дүгнэнэ. Оролцогч тус бүр асуултад хариулж дууссаны дараа шүүгчдийн өгсөн онооны нийлбэрээр хамгийн өндөр оноо авсан дарааллаар байр эзлүүлэн шагнаж, урамшуулна.

Дөрөв. Уралдааны зохион байгуулалт:

Уралдааны төгсгөлийн шатны шалгаруулалт тусгай хөтөлбөрөөр ивээн тэтгэгч байгууллагын сонгосон ресторанд зохион байгуулагдаж, БХЯ, ЗХЖШ-ын удирдлагын бүрэлдэхүүн оролцох бөгөөд БХЯ, ЗХЖШ, ХЗЦК, Соёмбо редакц, ҮБХИС-ийн БХЭШХ-ийн Цэргийн түүх судлалын төв, Nutag.mn вэбсайтаас томилогдсон шүүгчдийн бүрэлдэхүүн шүүн явуулна. Уралдааны төгсгөлийн шатны шалгаруулалт, шагнал гардуулах арга хэмжээг Nutag.mn веб сайт, “Дуулга” студийн цахим хуудсаар шууд дамжуулж, Nutag.mn вэбсайтын 21 аймаг дахь салбар, “Соёмбо” сонин болон цахим хуудас, “Соёмбо-мэдээ” өдөр тутмын цахим сонин, МҮОНТ-ээр цацагдах “Эх орны төлөө” нэвтрүүлгийн булангаар тус тус улс орон даяар төдийгүй дэлхийн өнцөг булан бүрд сурч, ажиллаж, амьдарч байгаа, тэрчлэн халуун цэгүүдэд үүрэг гүйцэтгэж байгаа энхийг сахиулагчдадаа хүргэн сурталчлах бөгөөд уралдааны оролцогчид хугацаат цэргийн алба хаах хугацаандаа социал хэрэгслээр өөрийгөө нээн харуулах, хөгжүүлэх, олны танил болж улмаар ажил олгогчдын анхааралд өртөж ажлын санал, урилга хүлээн авах, улмаар цэргийн албанаас бэлтгэлээр халагдсаны дараа шууд ажлын байртай болох зэрэг өргөн боломж, үүд хаалга нээгдэх юм.

Шагнал, урамшил:

1-р байр нэг. “Өргөмжлөл”, дурсгалын зүйл, Nutag.mn вэбсайтын нэрэмжит бэлэг;

2-р байр нэг. “Өргөмжлөл”, дурсгалын зүйл, Nutag.mn вэбсайтын нэрэмжит бэлэг;

3-р байр нэг. “Өргөмжлөл”, дурсгалын зүйл, Nutag.mn вэбсайтын нэрэмжит бэлэг;

Тусгай байр-2. “Өргөмжлөл”, дурсгалын зүйл, Nutag.mn вэбсайтын нэрэмжит бэлгээр тус тус шагнаж урамшуулна.

БАТЛАН ХАМГААЛАХЫН “СОЁМБО” РЕДАКЦ

АРДЫН ЭМЧ В.БАДАМСҮРЭНД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



олон өчигдөр түүнийг хүлээн авч хүндэтгэл үзүүллээ.

Ардын эмч В.Бадамсүрэн нь 1970 оны 7 дугаар сарын 14-нд Цэргийн төв эмнэлэгт мэс заслын эмчээр анх томилогдсоноосоо хойш 27 жил тус эмнэлэгтээ хоёргүй сэтгэлээр зүтгэж иржээ. Энэ хугацаанд бөөрний мэс заслын нарийн мэргэжлээр ЗХУ-ын Ленинград хотын С.М.Кировын нэрэмжит Цэргийн хүн эмнэлгийн академийг төгсөн Цэргийн төв эмнэлэгтээ анхны бөөрний мэс заслын эмчээр томилогдож, дараагаар нь Ерөнхий мэс заслын тасгийн дарга, Зүүнбаянгийн гарнизоны цэргийн эмнэлэгт мэс заслын зөвлөх эмчээр ажиллаж байсан удаатай.

Тэрээр 2013 онд Монгол Улсын хүний гавьяат эмч цолыг хүртсэн бол өнөө жил ийнхүү Ардын эмч цол хүртжээ.

Хүндэтгэл үзүүлэх үеэр тэрээр хэлэхдээ “Ардын эмч хэмээх энэ хүндтэй цолны эзэн болсондоо би маш их баяртай байна. Энэ бол бидний хамт олны олон жилийн хөдөлмөрийн үр шим юм. Өнөөдөр амьдралынхаа залуу, халуун насыг өнгөрөөсөн Цэргийн төв эмнэлгийн удирдлага, хамт олон намайг хүлээж авч байгаад туйлын баяртай байгаагаа илэрхийлэв. Цаашид цэргийн мэс засалч гэх энэ нэр хүндийг сэтгүүлэхгүй авч явахын төлөө ямагт зүтгэж явах болно” гэлээ.

ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБАНЫ БЭЛТГЭЛ СУРГАЛТ ЯВУУЛЛАА



Ховд аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын 2021 оны сургалтын төлөвлөгөөний дагуу цэргийн дүйцүүлэх албыг биеэр хааж байгаа иргэдтэй “Тусгай үүргийн бэлтгэл”, “Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл” сургалтуудыг Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн сургалтын материаллаг баазыг түшиглэн 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс 14 хоногийн хугацаатайгаар

халдвар хамгааллын дэглэмийг баримтлан зохион байгуулж явууллаа. Сургалтад хамрагдсан бүрэлдэхүүнд цэргийн хэргийн мэдлэг олгохоос гадна гүйцэтгэх үүрэгт нь чиглэсэн сургалтыг зохион байгуулж, батлан хамгаалах чиглэлээр гарсан хууль тогтоомжийг танилцуулан Батлан хамгаалах салбар Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгууллаа.

Хошууч Д.ТАМИР

Цэргийн төв эмнэлгийн нэгэн үеийн төлөөлөл, Монгол Улсын хүний гавьяат эмч, чөлөөнд байгаа дэд хурандаа В.Бадамсүрэнгийн анагаах ухааны салбарт нийт 51 жил

ажиллахдаа оруулсан хувь нэмэр, хичээл зүтгэлийг нь төр засаг өндрөөр үнэлж энэ жил түүнд Ардын эмч хэмээх эрхэм хүндтэй цолыг олгосон юм. Цэргийн төв эмнэлгийн удирдлага хамт

ОФИЦЕРЫН ЭГНЭЭНД ЭЛСЭВ





ЗХЖШ-ын даргын тушаалаар Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албаны тайван цагийн орон тоонд шинээр нөхөн хангагдсан хөдөө, орон нутгийн цэргийн хүрээ, хотхон хариуцсан тээврийн хяналтын байцаагчдын сургалт, цугларалтыг тус албанаас амжилттай зохион байгуулан явууллаа.

Сургалтаар нэгтгэл, анги, салбаруудын тээврийн

хэрэгслүүдэд хяналт шалгалт явуулах, зөрчил бүртгэх, осол хэргийн газарт ажиллах талаар заавар зөвлөгөө өгөв.

Үүний зэрэгцээ шинээр томилогдсон алба хаагчдад тусгааны болон албан тушаалын офицерын цол олгож, 2021 онд идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан алба хаагчдыг шагнаж урамшуулсан юм.

Ахлах дэслэгч Д.ГАНХУЯГ



* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)